



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1744

Чингис хот

Цэвэрлэгээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд 14 хоног тутамд нэг удаа өөрийн эзэмшил газар болон ойр орчмын 50 метр талбайд, айл өрх бүр хашааныхаа орчмын хог хаягдлаа тогтмол цэвэрлэхийг Хэрлэн сумын аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүдэд үүрэг болгосугай.

2.Үүссэн хог хаягдлыг аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хог хаягдал түр хадгалах саванд байршуулах, цэвэрлэгээ зохион байгуулсан тухай мэдээллийг харьяа багийн Засаг даргад хүргэж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3.Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хийлгэж хэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар заалт, Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийн хэрэгжилтийг биелүүлж ажиллахыг Хэрлэн сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР